



Багш мэргэжлээрээ хөгжих талаарх судалгааны сүүлийн үеийн тоймоос

Дэлэг Амартүвшин^{1*}, Цогт Одгэрэл²

¹ Монгол улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Багшийн сургууль, Математик байгалийн ухааны тэнхим

² Монгол улс, Эрдэнэт, Орхон аймаг 7-р сургууль, Захиргаа

*Холбоо барих зохиогч: amartuvshind@msue.edu.mn

Хүлээн авсан: 2020.11.24

Хянагдсан: 2021.04.07

Зөвшөөрсөн: 2021.05.12

Хураангуй

Энэхүү судалгаагаар багшийн мэргэжлийн хөгжилтэй холбоотой сүүлийн үеийн судалгаануудтай танилцах, багшийн хөгжлийн талаарх судалгааны эш үндэс, арга зүй, багшийн хөгжлийн үр өгөөжтэй загвар зэргийг олж мэдэх зорилгыг дэвшүүлж ажиллалаа. Судалгааны зорилготой уялдан, судалгааг хийхдээ эх сурвалж, баримт бичигт задлан шинжилгээ хийх аргыг хэрэглэлээ. Багш мэргэжлээрээ хөгжих талаарх Монголын болон гадаадын судлаачдын сүүлийн үеийн 19 бүтээлийг сонгож авсан бөгөөд түүний дөрөв нь тус бүр 30 гаруй өгүүлэлд задлан шинжилгээ хийсэн тойм судалгаа юм. Эрдэм шинжилгээний бүтээлийн сангаас тодорхой түлхүүр үгээр хайлт хийж сонгон авсан өгүүлэл, эх сурвалжуудад ямар хүрээнд, ямар хэрэгслээр багшийн хөгжлийг дэмжиж, хэрхэн хэрэгжүүлж, ямар үзүүлэлтийг шалгуур болгон сонгож, ямар үр дүнд хүрснийг шинжиллээ. Задлан шинжилгээний үр дүнг ерөнхийд нь нэгтгэвэл багш мэргэжлээрээ хөгжих арга зам ямар байхыг тогтоож, ямар загвар илүү үр дүнтэй байгааг тооцсон, багшийн мэргэжлийн хөгжил ба мэдээлэл харилцааны технологи (цаашид МХТ гэх) -ийн уялдаа холбоог тогтоосон, МХТ-ийн тусламжтайгаар багшийн мэргэжлийн хөгжлийн чиг хандлага хэрхэн өөрчлөгдөж байгааг тогтоосон судалгаанууд гол байр суурийг эзэлж байна. Багшийн мэргэжил дээшлүүлэх нэгдсэн сургалтад хамрагдахаас гадна ажлын байрандаа багш нар харилцах, хамтран ажиллах, бүтээлч үйлд оролцох замаар хөгжих боломжтой бөгөөд судлагдахуун, багшлах арга зүй, МХТ-ийн чадварыг хослуулан хөгжүүлэх замаар багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих боломжтой гэж дүгнэжээ.

Түлхүүр үг

Багшийн мэргэжлийн хөгжлийн загвар, МХТ, ТРАСК мэдлэг

Удиртгал

2019 оны 1-р сарын 1-ээс Монгол улсад “Багшийн хөгжлийг дэмжих хууль” хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой сургууль бүр багшийн хөгжлийн хөтөлбөртэй байх шаардлагатай болсон. Ажлын байран дээрээ хамтран хөгжихийг дэмжих үр дүнтэй, хэрэгжихүйц загвар, хөтөлбөрийг боловсруулахын тулд багшийн

хөгжлийн талаар сүүлийн үеийн судлагдсан байдлыг тоймлон судалж, тэдгээрт үндэслэн, багшийн хөгжлийн нэгэн загварын онолын болон арга зүйн үндэслэлийг боловсруулах шаардлага үүсэж байна. Монгол улс 1956 оноос 2002 хүртэл бие даасан багшийн мэргэжил дээшлүүлэх институт, хүрээлэнтэй байжээ. 2002-2012 он хүртэл багш бэлтгэх их сургуулиуд, Боловсролын хүрээлэнг түшиглэсэн багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоотой байсан бөгөөд 2012 онд Багшийн мэргэжил дээшлүүлэх институт бие даан байгуулагдаж, эдүгээ багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоот үйл ажиллагаа явуулж байна. Сүүлийн жилүүдэд онлайн хэлбэрээр багшийн цахим кампусаар багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа зохион байгуулагдаж, цахим ба танхимын үйл ажиллагаа хослон өрнөх болжээ (БМДИ, 2018, х.7). Судалгааны зорилго нь багшийн хөгжлийн талаарх сүүлийн 20 жилийн судалгааны бүтээлүүдэд задлан шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэж, тоймлох, багшийн хөгжлийн шинэ загварыг боловсруулан туршихын тулд судлагдсан байдлыг тогтоох явдал юм. Зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүллээ. Үүнд: 1.Судалгаанд хамрагдах өгүүлэл, эх сурвалжийг сонгох, 2.Уншиж судлах, 3.Эх сурвалжид задлан шинжилгээ хийх аргачлалыг боловсруулах, 4.Задлан шинжилгээ хийх, 5.Задлан шинжилгээ дээрээ тулгуурлан дүгнэлт гаргах. Энэхүү зорилтуудыг биелүүлэхийн тулд дараах арга зүйг хэрэглэлээ. Судалгаанд хамрагдах өгүүлэл, эх сурвалжийг багшийн мэргэжлийн хөгжлийн талаарх сүүлийн үеийн бөгөөд олон судалгааг хамруулсан судалгааны тойм, бусад судлаачдад нэлээд эшлэгддэг өгүүлүүдийг эрдэм шинжилгээний бүтээлийн голлох хайлтын системүүдээс тодорхой түлхүүр үгээр хайлт хийх замаар сонголоо. Сонгож авсан эх сурвалждаа задлан шинжилгээ хийхдээ 1.Судалгааны хамрах хүрээ, 2.Багш мэргэжлээрээ хөгжихийг дэмжих хэрэгсэл, 3.Түүнийг хэрэгжүүлсэн байдал, 4.Үнэлсэн шалгуур, 5.Гарсан үр дүн зэрэг элементийг сонгож, тухайн эх сурвалжид тэрхүү элемент хэрхэн тусгагдсан, түүнийг юугаар хэрхэн хэмжсэнийг авч үзлээ. Багшийн хөгжлийн үр дүнтэй загварыг боловсруулан, туршиж, боловсролын чанарт хувь нэмэр оруулахын тулд шинжлэх ухааны үндэслэлтэй, улс орны нөхцөлд нийцсэн, хэрэгжихүйц, цаг үеийн шаардлага хангасан үйл ажиллагааг төлөвлөх хэрэгтэй байна. Үүний нэг үндэс нь өмнөх үеийн судалгааны үр дүнг судлан, тэдгээрээс суралцах, улам сайжруулах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүй, багшийн хөгжлийг дэмжих загвар, хөтөлбөрөөс суралцах зэргийг анхаарах явдал юм.

Монголын судлаачдын судалгаанаас

Багшийн хөгжлийн талаарх судалгаанд Б.Жадамбаа, Ч.Пүрэвдорж, С.Батхуяг, Н.Бэгз, Д.Мөнхжаргал, Ч.Байгалмаа, С.Энхтүвшин, Б.Булган нарын бүтээлүүд голлох байр суурь эзэлж байна.

Багшийн хөгжлийн талаарх ерөнхий үзэл баримтлал, хэрэгцээ шаардлага, ач холбогдол талаас нь дараах судлаачдын бүтээлд судлагджээ. Үүнд:

- Н.Бэгз боловсролын хөгжлийн асуудлыг цогцоор нь авч үзэн, манай улсын боловсролын салбарын болон гадаад улсуудын боловсролын хөгжлийн онолчдын үзэл баримтлалыг тоймлон, тэдгээр нь багшийн хөгжлийн бодлоготой хэрхэн холбогдож байгааг дурджээ (Бэгз, 2008, х.89).
- Ч.Пүрэвдорж багшийн хөгжлийг боловсролын менежментийн ухааны үүднээс судлан, сургууль болон багшийн ажлыг шинэчлэх үндсэн нөхцөл нь багшийн хөгжил гэж үзжээ (Пүрэвдорж, 2011, х.396). Тэрээр ажлын байран дээрээ багшийн хөгжих гол арга зам бол бүтээлч эргэцүүлэл гээд түүнийг багшийн

мэргэжлийн хөгжлийн хөдөлгөгч хүч, мотортой зүйрлэжээ (Пүрэвдорж, 2011, х.410).

- Б.Жадамбаа Монголын багш нарын 7-р их хурал дээр “Улсын хөгжил-хүнээсээ, хүний хөгжил-багшаасаа, багшийн хөгжил-бодлогоосоо” илтгэлд багшийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг улс орны хөгжлийн мөн чанартай холбон, “Багшийн хөгжил зөв бол улсын хөгжил зөв” гэж тодорхойлжээ (Жадамбаа, 2019, х.55).
- С.Батхуяг багшийн хөгжлийн философи үндэслэлийг боловсрол судлалын шинжлэх ухааны үүднээс тайлбарлан, “багш хүн өөрийн үеийнхэнтэй бус шинэ үеийнхэнтэй ажилладаг учраас бусдаас түрүүлж, шинэчлэгдэн хөгжих ёстой” гэж үзжээ (Батхуяг, 2020, х.81).

Багшийн хөгжлийн арга зам, загвар, хэрэгслийн талаарх судалгаануудаас монгол хэл дээрх эх сурвалжийг ШУТС-гийн диссертацийн сангаас “багшийн хөгжил”, “багшийн мэргэжлийн хөгжил” түлхүүр үгээр хайлт хийхэд гарч ирсэн 2000 оноос хойших диссертац, МУБИС-ийн номын сангийн катологиос “багшийн хөгжил” гэсэн түлхүүр үгээр хайхад гарч ирсэн бүтээлүүдийг сонгож авлаа. Үүнд:

- Д.Мөнхжаргал нарын боловсруулсан 21-р зууны багшийн загварын судалгаанд багшийн хөгжлийн өнөөгийн чиг хандлагыг тодорхой дүгнэн, Монгол багшийн 21-р зууны загварыг боловсруулжээ (Мөнхжаргал & Энхтүвшин, 2015, х.18). Энэхүү загварыг боловсруулсан төслийн тайланд багшийн хөгжлийн талаарх голлох эрдэмтдийн судалгааны үр дүнг багтаажээ.
- Ч.Байгалмаа багш хөгжлийг мэргэжлийн практик үйл ажиллагаандаа тулгуурлан хөгжих боломжийг судлан, түүн дотроос бүтээлч эргэцүүлэл, үйлийн судалгааг онцлон багшийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг тогтоосон судалгаа хийжээ (Байгалмаа, 2009, х.108).
- Ц.Бурмаа англи хэлний багшийн ангид гадаад хэлний багшлах, суралцахуйн үр дүнтэй стратеги бүхий арга зүйгээр хичээл зохион байгуулж, оюутнуудын хэлний чадварын үзүүлэлт ахисныг харуулжээ (Бурмаа, 2013, х.6).
- Б.Булган багшийн хөгжлийн хөшүүрэг нь бүтээлч үйл бөгөөд бүтээгч багшийн загварыг боловсруулан туршиж, үр дүнг тооцсон байна. Тэрээр бага ангийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан багш нарын бүтээлч даалгавар гүйцэтгэсэн байдал, тэрхүү даалгавар нь тухайн багшийн мэргэжлийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг судалсан байна (Булган, 2014, х.19).

ЕБС-ийн багш нарын ажлын байран дээрээ хөгжих боломжийг судлан, түүгээрээ магистрын зэрэг горилох бүтээл туурвих, БМДИ-ээс зарласан илтгэлийн уралдаанд оролцсон тохиолдол олон байна. Нэгэн жишээ дурдахад 2015 онд МУБИС-ийн магистр Д.Бадамцэцэг “Багш нар ажлын байран дээр багаар хамтрах хөгжих нэгэн боломжийг судалсан нь” сэдвээр судалгааны ажлаа танилцуулж, магистрын зэрэг хамгаалжээ. Түүний судалгаанаас багш нар багаар зохион байгуулагдаж, тодорхой зорилго дэвшүүлж ажиллавал мэргэжлийн ахиц дэвшил гарч байна” гэж дүгнэжээ (Бадамцэцэг, 2015, х.48).

Гадаадын судлаачдын сүүлийн үеийн судалгаанаас

Багшийн мэргэжлийн хөгжлийн талаарх онолын үндэслэл болох эх сурвалжуудаас онцлон дараах бүтээлийг сонгож авлаа. Лев Выгодскийн (1978) нийгэм соёлын онол бол багшийн хөгжлийн онол, үзэл баримтлалуудын эш үндэс болно. Нийгмийн харилцаанд оролцох үедээ харилцан идэвхтэй үйл ажиллагаанд оролцсоноор шинэ зүйл суралцаж, мэдлэг, чадвар, хандлагад эерэг ахиц гарна гэж тэрээр үзжээ. Нэгэн сургуулийн багш нарын хамт олон гэдэг бол тухайн сургууль

дээр үүссэн нийгмийн нэгэн бүлэг болох бөгөөд тэд хамтаар идэвхтэй үйл ажиллагаануудад оролцсоноор хөгжих санааг түүний “Нийгэм дэх оюун ухаан” бүтээлээс харж болно (Vygotsky, 1978, х.79). Мөн Линда Дарлинг-Хаммонд нар (2006) “Өөрчлөгдөж байгаа дэлхий ертөнцөд багшийг бэлтгэх нь” гэдэг номондоо 21-р зууны багш бол сургалт болон суралцагчийн тухай мэдлэг, заах судлагдахууны тухай мэдлэг, арга зүйн тухай мэдлэгийн огтлолцол дээр бэлтгэгдэх ёстой гэж үзжээ. (Linda Darling-Hammond, John Bransford, Pamela LePage, & Karen Hammerness, 2007, х.2). Энэ санааг мөн олон судлаачид багш бэлтгэх хөтөлбөрийг шинэчлэхэд ашиглахыг зөвлөсөн байдаг (Damon L.Bahr, Lisa Ann DeGarcia, 2008, х.8). Гадаад хэл дээрх өгүүлэл, эх сурвалжийг сонгож авахдаа springer.com болон googlescholar.com веб сайтаас “teacher development”, “teacher professional development” хайлтаар илэрсэн илэрцээс 2000 оноос хойших өгүүлүүдээс сонгож авч, он дарааллын дагуу товч агуулгыг орууллаа. Үүнд: Мэй Бритт Постхолмын судалгаа: Энэхүү судалгаа нь Web of Science-д багтах сэтгүүлүүдийн 2009 оноос 2011 оны 8-р сарыг дуустал оныг дуусталх дугааруудаас “багш боловсрол”, “багшийн хөгжил”, “багшийн мэргэжлийн хөгжил” гэсэн түлхүүр үгээр хайлт хийхэд илэрсэн 31 өгүүллийн онолын үндэслэл болон судалгааны үр дүнд задлан шинжилгээ хийжээ (Postholm, 2012, х.405). Түүний энэхүү судалгаа нь “Туршлагатай багш хэрхэн суралцаж хөгждөг вэ?” гэсэн асуултад хариулт эрсэн бөгөөд багш нарын мэргэжлийн хандлага “ярьж тайлбарлах” цаг үеэс конструктив үзэл баримтлал, метакогнитив хандлага руу шилжсэн гэсэн дүгнэлтэд хүрчээ. Тэрээр “ярьж тайлбарлах” үеийн дэвшилтэд судалгаанд Schwartz, Bransford нарынхаар (1998) конструктивист парадигм хэмээн тэмдэглэж, Выгодскийн нийгмийн конструктивизмын үндэс болсон диалогийн тухай (Vygotsky, 1978, х.14) үзэл санааг багшийн хөгжлийг дэмждэг хэмээн үнэлжээ (Postholm, 2012, х.407). Мөн багш сургуулийн орчинд хамт ажилладаг хүмүүстэй ярилцаж, диалогт оролцох нь тэдний хувьд “ойрын хөгжлийн бүс” бөгөөд сургууль нь нийгэм соёлын контекст болж буйг тайлбарлажээ. Мөн Бахтины судалгаанд багшийн дотоод диалоги нь тэдний ойлголтыг дэмждэг гэдгийг онцолжээ. Метакогнитив сургалтын үед Жон Дьюгээс Фравелл, Зиммерман нар хүртэлх судлаачдыг хамруулан, тухайн судлаач бүрийн багшийн хөгжлийг хэрхэн дэмжих боломжтой гэж үзсэнийг дурджээ. Сургуулийн эерэг соёл, сайн харилцааны уур амьсгал багшийн хөгжилд нөлөөлөх гадаад хүчин зүйл болдог. Багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалт хэрэгтэй ч ажлын байран дээр өрнөж байгаа багшийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаанууд сургуулийн соёлыг эергээр өөрчилж, тэр нь бүтцийг өөрчилж байдаг гэжээ (Postholm, 2012, х.408). Линда Дарлинг-Хаммонд нарын судалгаа (2017): Линда Дарлинг-Хаммонд, Мариа Хайлер, Маделин Гарднер, туслах Данни Еспиноза нарын “Багшийн мэргэжлийн үр дүнтэй хөгжил” нэртэй төслийн тайланг 2017 онд АНУ-ын Суралцахуйн бодлогын хүрээлэнгийн захиалгаар хэвлэсэн байдаг (Darling-Hammond, L., Hyster, M., Gardner, M., 2017, х.1). Энэхүү судалгааг боловсролын бодлого боловсруулагчид, орон нутаг, сургуулийн удирдлагууд, судлаачид, багш нарт зориулж хийсэн. Уг судалгаанд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны ажлыг хэвлэдэг сэтгүүлүүд, онлайн платформууд дээр байрлах, тухайн судлаачдын дэвшүүлсэн шаардлага болох 1) туршилтын болон хяналтын бүлгийг харьцуулсан байх, 2) багшийн хөгжлийн загварыг сурлагын амжилттай хамааралтай эсэхийг тооцсон байх гэсэн шаардлагыг хангах 2017 оноос өмнөх 30 жилд бичигдсэн 35 өгүүллийг сонгон авч, задлан шинжилгээ хийж, загвар ямар бүтэцтэй, ямар элементүүдийг агуулсан байвал сурлагын амжилтад

эергээр нөлөөлж байна вэ гэдгийг тогтоосон байна. Судалгааны тайлан 3 хавсралттай бөгөөд А хавсралтад өөрсдийн судалгааг хийсэн арга зүйг, В хавсралтад судалгаанд хамрагдсан өгүүллийн сэдэв, товч танилцуулга, арга зүй, үр дүн зэргийг танилцуулж, С хавсралтад судалгаа бүрд хэрэглэсэн багшийн хөгжлийн загварын элементүүдийг ялган авч харуулсан байна. Судалгаанд хамрагдсан 35 өгүүллийн хувьд олон сургууль (1-1122 сургууль), багш нар (хамгийн олон нь 750), суралцагчдыг (хамгийн олон нь 22506) хамарсан бөгөөд SAT, NAEP, TEL, Peabody Test гэх мэт стандартчилагдсан тестүүдийг хэрэглэн, сурлагын амжилтыг хэмжжээ. Энэхүү судалгааг хийсэн судлаачид дээрх 35 өгүүлэлд задлан шинжилгээ хийсний үндсэн дээр багшийн хөгжлийн загварыг үр дүнтэй болгох элемент хэмээн дараах 7 зүйлийг нэрлэсэн байна. Үүнд: 1) агуулга, 2) идэвхтэй сургалт 3) хамтын ажиллагаа 4) загвар 5) ментор 6) эргэцүүлэл, хариу мэдээлэл 7) тогтвортой хугацаа. Эдгээр 7 элементийг хамрах хүрээний 35 өгүүлэлд хэр зэрэг ашиглагдсаныг тогтооход 35 судалгааны хамгийн багадаа 31, түүнээс олон судалгаанд нь илэрсэн байна (Darling-Hammond, L., Nyler, M., Gardner, M., 2017, х.48). Энэхүү судалгааны тойм өгүүлэл нь дараагийн судлаачдад баталгаатай, найдвартай дүгнэлт мэдээлэл болох бөгөөд багшийн хөгжлийн хөтөлбөр, загвар боловсруулахад үндэс болж чадах бүтээл болсон. Бид судалгаанд хэрэглэсэн загварыг боловсруулахдаа мөн дээрх элементүүдийг харгалзаж үзсэн. Багшийн хөгжлийн талаар эх сурвалж болгон ашигласан 136 ном, гарын авлага, өгүүлэл ном зүйд бичигджээ. Бидний судалгааны хүрээнд судлагдсан нэг гол өгүүлэл бол Матью Коехлр, Пуниа Мишра (2009) нарын TRACK-ийн тухай өгүүлэл юм. Энэхүү өгүүлэлд технологижсон, арга зүйжсэн, агуулгын мэдлэг буюу TRACK хэмээх мэдлэгийн шинэ хэлбэрийг хэрхэн боловсруулсан, ямар үр дүнтэй байгаа, мэдлэгийг дүрсэлсэн зургийн муж бүр ямар онцлогтой, ямар элементүүдийг агуулж байгааг дэлгэрэнгүй авч үзжээ (Koehler, M. J., & Mishra, P. Kereluik, K. Tae Seob Shin, and Charles Graham, 2009, х.60). TRACK мэдлэгийн гол санаа бол Линда Дарлинг-Хаммондын (2006) өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд багшийг бэлтгэх санааг МХТ-ийн чадвартай хослуулж авч үзсэнээрээ онцлогтой. Энэ нь аж үйлдвэрийн 4-р хувьсгалаас хойш сургалтад МХТ ба дижитал технологи түлхүү орж ирэх хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа гэж үзэж байна. Нэн ялангуяа өнөөгийн цар тахлын улмаас цахим хичээл судлах хэрэгцээг хангахад багш бүрээс МХТ-ийн болон цахим контент бэлтгэх мэдлэг, чадварыг шаардаж байна.

- 2016 оноос хойш багшийн мэргэжлийн хөгжлийн талаар хийгдсэн судалгаанууд ихэвчлэн багшийн мэргэжлийн хөгжлийг МХТ-той хэрхэн холбох, тэдгээрийн холбоо хамаарлыг тооцсон, багшийн хөгжлийг дэмжих арга замыг МХТ-ийн тусламжтай шийдсэн зэрэг шинж чанартай байна. Тухайлбал, 2016 онд хэвлэгдсэн Жо Тондээр нарын “Багшийн мэргэжлийн хөгжлийг МХТ-той хослуулснаар бэрхшээлүүдийг даван туулах нь” сэдэвт өгүүлэлд Израйл, Кени, Австрали, Шри-Ланк зэрэг дөрвөн орны багшийн мэргэжлийн хөгжлийн бодит жишээн дээр багшийн хөгжлийн тулгамдсан асуудлыг МХТ-ийн тусламжтай шийдвэрлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа гэж дүгнэжээ (J Tondeur, Forkosh-Barush, S.Prestridge, P.Albion, & S. Edirisigne, 2016, х.111).
- 2017 онд хэвлэгдсэн Сингапурын судлаачид болох Лин Ко, Син Чай, Еин Лим нарын “TRACK-г зориулсан 21-р зууны суралцахуйн багш мэргэжилтний хөгжил: Багшийн МХТ-ийн чадварын үр өгөөж ба сурагчдын амжилт” өгүүлэлд Сингапурын бага сургуулийн 37 багшийг сонгож, 7 баг болгон зохион байгуулж, 21-р зууны сургалт, TRACK мэдлэгийн үзэл санаагаар хичээлийн төлөвлөлт хийхэд анхаарч ажиллахад 7 багийн 5 багт нь эерэг үзүүлэлтүүд гарч, сурагчдын

сурлагын амжилт, үр дүн нэмэгдсэн байна (Joese Hwee Ling Koh, Ching Sing Chai & Wei Ying Lim, 2017, х.174).

- 2020 онд хэвлэгдсэн Баруун Виржинагийн Их сургуулийн судлаачид болох Угур Кейл, Абхик Рой, Жианмей Юан нарын “Төлөвлөх үү эсвэл нэгтгэх үү?: Сургалтын төлөвлөлтийг технологийн нэгдмэл байдалтай харьцуулсан нь” өгүүлэлд судалгаанд хамрагдсан хоёр бүлэг багш нарыг ахлах ангид зориулан зааварчилгааны загвар ба ТРАСК ашиглан хичээлийн төлөвлөлт, зохион байгуулалт, арга зүйг шийдэж, үр дүнг нь нийгмийн сүлжээний задлан шинжилгээний аргаар судлахад эерэг үр дүн гарсан байна (Ugur Kale, Abhik Roy, & Jiangmei Yuan, 2020, х.2479).
- Мөн Индонезийн судлаач Али Имрон нарын 2020 онд нийтлүүлсэн “Азийн эдийн засгийн хамтын нийгэмлэгийн эрин үед багшийн мэргэжлийн хөгжлөөр багшийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх нь” сэдэвт өгүүлэлд уг бүс нутгийн боловсролын чанарт багшийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх нь нөлөөлж байгаа бөгөөд багшийн мэргэжлийн хөгжлийн загвар багшийн хэрэгцээнд тулгуурлаж бүтээгдэнэ гэж дүгнэжээ (Ali Imron et al, 2020, х.340). Эдгээр эх сурвалжаас харахад багшийн мэргэжлийн хөгжлийн нэгэн хүчин зүйл нь МХТ болж байгааг харуулж байна. Мөн Springer-ээс хэвлүүлсэн Берт Криймерс, Леонидас Кириакайдс, Панаиотис Антонио (2013) нарын зохиосон “Багшлахуйн чанарыг сайжруулахад Багшийн хөгжил” ном нь Азийн хөгжлийн банкны тусламжаар монгол хэлнээ хөрвүүлэгдсэн байдаг. Энэ бүтээлд 1) Багш бэлтгэх сургалт, багшийн хөгжлийн судалгаа, 2) Багшийн үр өгөөжийн судалгааны гол үндэс, 3) Багшийн үр дүнгийн судалгааг багш бэлтгэх сургалтын болон багшийн хөгжлийн судалгаатай холбох нь гэсэн үндсэн 3 бүлгээс тогтох бөгөөд багшийн хөгжлийн парадигмууд, багшийн хөгжлийн загварууд, багшийн хөгжлийн судалгааны тойм, багшийн хөгжлийн тодорхой кейсүүдийг багтаасан практик хэрэглээ бүхий гарын авлага юм. Тусгайлан “Багшийн хөгжлийн судалгаанд санал болгох нь” гарчиг бүхий 4 зүйн зөвлөмжийг энэ чиглэлээр судалгаа хийх судлаачдад зориулан гаргажээ. Мөн багшийн хөгжлийн динамик нэгдмэл хандлага, чадамжид суурилсан хандлага гэсэн ухагдахуунуудыг гол болгосон байдаг (Берт Криймерс, Леонидас Кириакайдс & Панаиотис Антонио, 2013, х.24).

Судалгааны үр дүн

Хэдийгээр багшийн мэргэжлийн хөгжлийн талаарх бүх судалгааг бүрэн хамруулаагүй боловч багшийн мэргэжлийн хөгжлийн талаарх судалгааны хүрээнд бүрэн ашиглагдах онолын үндэслэл болон судалгааны арга зүй, судалгааны үед анхаарах зүйлс, багшийн хөгжлийн загварыг боловсруулахдаа анхаарах зүйлс, тусгах ёстой элемент зэрэг мэдээллийг дээрх эх сурвалжийн хүрээнд задлан шинжилгээ хийлээ. Задлан шинжилгээг монгол судлаачдын болон гадаадын судлаачдын гэж ангилж харуулбал:

- Монгол судлаачдын өгүүлэлд хийсэн шинжилгээ
Хүснэгт 1-с харахад дээрх судлаачид багш хүн мэргэжлээрээ хөгжихийг дэмжихдээ тодорхой үйлийг (эргэцүүлэл, үйлийн судалгаа, төсөлт ажил, шинэлэг арга зүй) сонгон авч мэргэжил дээшлүүлэх сургалт, их сургуулийн хичээлээр хэрэгжүүлж, багш нарын мэргэжлийн хөгжлийг багшийн сэтгэл ханамж, өөрийн үнэлгээ гэх мэт чанарын үзүүлэлт, мөн чадварын ахиц болох зарим тоон үзүүлэлтүүдээр хэмжжээ.

Хүснэгт 1

Монгол судлаачдын эх сурвалжуудын шинжилгээ

№	Зохиогч, он, эх сурвалжийн нэр (төрөл)	Хамрах хүрээ	Багшийн хөгжлийг дэмжих зүйл	Түүнийг хэрэгжүүлсэн байдал	Хэмжсэн шалгуур	Гарсан үр дүн
1	Ч.Байгалмаа, (2009), Багш, мэргэжлийн практик үйл ажиллагаандаа тулгуурлан хөгжих явцын судалгаа (диссертац)	Хэнтий, Төв аймгийн дунд сургуулийн 272 багш	Бүтээлч эргэцүүлэл, үйлийн судалгаа	Мэргэжил дээшлүүлэх модуль сургалт	Багш нарын сэтгэл ханамж, өөрийн үнэлгээ	Практик үйлээр багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих арга зүй
2	Ц.Бурмаа, (2013), Continuing teachers development (өгүүлэл)	Англи хэлний багшийн ангийн оюутнууд	Бүтээлч стратеги бүхий шинэ арга зүй	“LLS бүхий багшлах арга зүй” сонгон судлах хөтөлбөр	Оюутнуудын англи хэлний үндсэн чадварууд	Тоон үзүүлэлтийн ахиц
3	Б.Булган, (2014), Бүтээгч багшийн хөгжил төлөвшлийг дэмжих төсөлт ажлын онол арга зүйн судалгаа (диссертац)	Бага ангийн 1081 багш, БС-ийн төгсөх ангийн оюутнууд	Төсөлт ажлын арга зүй	Мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулсан.	Багш нарын сэтгэл ханамж, өөрийн үнэлгээ	Багшийн бүтээлч чанарыг дэмжих төсөлт ажилд суурилсан арга зүй

- Гадаадын судлаачдын өгүүлүүдэд хийсэн шинжилгээ

Энэ бүлэгт хамрагдах өгүүлүүдийг а. Тойм өгүүлэл, б. Дагнасан өгүүлэл хэмээн ангилж авч үзлээ. а. Тойм өгүүллийн хувьд:

Хүснэгт 2

Гадаадын судлаачдын тойм өгүүлэлд хийсэн шинжилгээ

№	Зохиогч, он, өгүүллийн нэр	Хамрах хүрээ	Багшийн хөгжлийг дэмжих хэрэгсэл	Түүнийг хэрэгжүүлсэн байдал	Хэмжсэн шалгуур	Гарсан үр дүн
1	Постхолм нар, (2009), “Teacher's professional development: a theoretical review”	Web of Science жагсаалтын 31 өгүүлэл	Багш нарын суралцах арга зам	Сургуулийн орчин, эерэг соёл, багш нарын хамтын ажиллагаа, тогтолцоот мэргэжил дээшлүүлэх сургалт	Тэнхлэгийн задлан шинжилгээний 7 үзүүлэлт	Туршлагажсан багш нар хэрхэн суралцдагийг тогтоосон
2.	Линда Дарлинг Хаммонд нар, (2017),	Web of Science жагсаалты	Мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүд	Өгүүлэл бүрийн хувьд өөр өөр	Ихэвчлэн сурагчдын сурлагын	Багшийн мэргэжил дээшлүүлэх үр өгөөжтэй

	“Багшийн мэргэжлийн үр дүнтэй хөгжил”	н 35 өгүүлэл		үндэсний хэмжээнд хөтөлбөр хэрэгжүүлэх замаар багшийн хөгжлийг дэмжсэн	амжилтыг хэмжсэн.	хөтөлбөрийн элементүүдийг тодорхойлсон
3.	Матью Коелр, Пуниа Мишра, (2009) “What is technological pedagogical content knowledge?”	Шууд холбоо бүхий 66 бүтээл, шууд бус холбоотой 303 бүтээл	ТРАСК мэдлэг	Өөрийн үнэлгээ, нээлттэй асуулт, ярилцлага, гүйцэтгэлд суурилсан үнэлгээ зэрэг 141 хэрэгсэл	Багш болон багшаар суралцаж буй оюутнуудын ТРАСК мэдлэгийн хэрэглээ, ойлголт	ТРАСК мэдлэгийн дүрслэл
4	Али Имрон нар, (2020), “АСЕАН-ы ЭЗН-ийн эрин үед багшийн мэргэжлийн хөгжлөөр багшийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нь”	Энэ бүс нутгийн багшийн хөгжлийн талаарх өгүүлэл, ном, цахим болон цаасан мэдээлэл	ЭЗ-ийн хөгжил, чөлөөт зах зээлийн өсөлт	Багшийн хөгжлийн загвар	Багшийн өрсөлдөх чадвар	АЕС эриний багш нарын өрсөлдөх чадварын хэлбэр, багшийн мэргэжлийн хөгжил нь өрсөлдөх чадварыг оновчтой болгохыг тогтоосон

Эдгээрийг нэгтгэн дүгнэхэд багшийн хөгжлийг тогтолцоот албан ёсны хөтөлбөр, курсээр дэмжихээс гадна ажлын байран дээрээ хамтран ажиллах, үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлэх замаар дэмжих боломжтой бөгөөд багшийн хөгжлийн хөтөлбөр ямар элементүүдээс тогтсон байвал үр дүнтэй болохыг тогтоожээ. Мөн МХТ-ийн тусламжтайгаар багшлах арга зүй болон судлагдахууны нэгдлийг (ТРАСК) эзэмшин хөгжихийг шаардаж байгааг тогтоосон байна. Дээрх шинжилгээнээс харахад гадаадын судлаачдын судалгаанд багшийн хөгжлийг үнэлэхдээ суралцагчдынх нь сурлагын амжилт гэх мэтийн тоон үзүүлэлтийг шалгуур болгох, контент анализ, нийгмийн сүлжээний анализ гэх мэт аргуудыг хэрэглэх хандлага харагдаж байна. Мөн тухайн сэдвийн олон өгүүллийг тоймлон шинжлэх, аль нэг улсын хэмжээнд эсвэл улс дамнасан судалгаа зохион байгуулсан зэрэг онцлог харагдаж байна. Нийтлэг шинж чанар нь багшийн мэргэжлийн хөгжилд МХТ ба ТРАСК мэдлэгийн үүрэг, нөлөөг тооцсон байна.

6. Тойм бус өгүүллийн хувьд

Хүснэгт 3

Гадаадын судлаачдын өгүүлэлд хийсэн шинжилгээ

№	Зохиогч, он, өгүүлэл	Хамрах хүрээ	Багшийн хөгжлийг дэмжих зүйл	Түүнийг хэрэгжүүлсэн байдал	Хэмжсэн шалгуур	Гарсан үр дүн
1	Жо Тондизэр нар, (2016), “Багшийн мэргэжлийн хөгжлийг МХТ-той хослуулснаар бэрхшээлүүдийг даван туулах нь”	Кени, Австрали, Израйл, Шри-Ланкийн жишээ	МХТ	Багшийн мэргэжлийн хөгжлийн хөтөлбөр, 2015 он EDUsummIT чуулганы хэлэлцүүлэг	Багшийн мэргэжлийн хөгжлийн 5 асуудлыг давсан туулсан байдал	Багшийн мэргэжлийн хөгжил МХТ-ийн нөлөөллийг тогтоосон
2	Лин Ко, Син Чай, Еин Лим, (2017), “ТРАСК-г зориулсан 21-р зууны суралцахуйн багш мэргэжилтний хөгжил: Багшийн МХТ-ийн чадварын үр өгөөж ба сурагчдын амжилт”	Сингапурын бага сургуулийн 37 багш	21-р зууны сургалт, ТРАСК мэдлэг	Хичээлийн төлөвлөлтийн өөрчлөлт	Сурлагын амжилт, багшийн МХТ-ийн чадвар	Сурлагын амжилтад эерэг ахиц гарсан
3	Угур Кейл, Абхик Рой, Жианмей Юан, (2020), “Төлөвлөх үү эсвэл нэгтгэх үү?: Сургалтын төлөвлөлтийг технологийн нэгдмэл байдалтай харьцуулсан нь”	22 багш бүхий хоёр бүлэг	Сургалтын төлөвлөлт (IDK) ба ТРАСК харилцан хамаарал	Судалгаанд хамрагдсан багш нарын онлайн сургалт	Агуулгын ба нийгмийн сүлжээний задлан шинжилгээний шалгуурын өөрчлөлт	Судалгаанд оролцогчдын IDK ба ТРАСК хамаарал

Дүгнэлт

Хэдийгээр багшийн мэргэжлийн хөгжлийн талаарх бүх судалгааг бүрэн хамруулаагүй боловч сонгож авсан эх сурвалжуудад хийсэн задлан шинжилгээ дээр тулгуурлан дараах дүгнэлтийг хийлээ.

1. Багшийн мэргэжлийн хөгжлийн судалгаа нь олон тооны сургууль, багш нар, сурагчдыг хамруулан, урт хугацаанд зохион байгуулагддаг. Эсвэл багшийн мэргэжлийн хөгжлийн талаарх өмнө хийгдсэн судалгаануудыг хамруулан, задлан шинжилгээ хийж тоймлон авч үзжээ.

2. Эх сурвалжуудын дийлэнхэд багш нарын ажлын байран дахь харилцаа, хамтын ажиллагаа, арга зүйн өөрчлөлт нь тэднийг мэргэжлээрээ хөгжих хүчин зүйл болдог гэжээ. 21-р зууны багшийн мэргэжлийн хөгжлийн хүрээнд ТРАСК мэдлэг чухал байр суурь эзэлж байна.
3. Багшийн мэргэжил дээшлүүлэх албан ёсны хөтөлбөр, албан бус ажлын байран дээрх хамтын ажиллагаа, онлайн сургалт, практик үйл, тодорхой арга зүйн шийдэл бүхий өөрчлөлтөөр багшийн хөгжлийг дэмждэг ажээ.
4. Багшийн мэргэжлийн хөгжлийг багшийн сэтгэл ханамж, өөрийн үнэлгээ, өрсөлдөх чадвар, тулгамдсан асуудлын шийдлийн жишээ зэрэг чанарын үзүүлэлт, сурлагын амжилт зэрэг тоон үзүүлэлтийг хэмжих замаар илрүүлж байна.
5. Сонгогдсон судалгаануудын үр дүнд багшийн мэргэжлийн хөгжлийн өгөөжтэй хөтөлбөр, загвар, арга зүйг боловсруулж, голлох хүчин зүйлүүдийг тогтоож, сүүлийн үеийн чиг хандлагыг тодорхойлсон байна.

Ном зүй

- Ali Imron, Bambang Budi Wiyono, Syamsul Hadi, Imam Gunawan, Asghar Abbas, Bagus Rachmad Saputra & Dyas Bintang Perdana. (2020). Teacher Professional Development to increase Teacher Commitment in the Era of the Asean Economic Community. *Advanced in Social Science, Education and Humanities Research*. vol 487, 339-343.
- Damon L. Bahr, Lisa Ann DeGarcia. (2008). *Elementary mathematics is anything but elementary*. MA: Cengage Learning.
- Darling-Hammond, L., Hyster, M., Gardner, M., (2017). *Effective Teacher Professional Development*. CA: Learning Police Institute.
- J Tondeur, Forkosh-Barush, S. Prestridge, P. Albion, & S. Edirisighe. (2016). Responding to Challenges in Teacher Professional development for ICT Integration in Education. *Educational Technology & Society* 19(3), 110-120.
- Joese Hwee Ling Koh, Ching Sing Chai & Wei Ying Lim. (2017). Teacher Professional development for TPACK-21CL: Effects on Teacher ICT integration and Student Outcomes. *Journal of Educational Computing Research*. Vol 55(2), 172-196.
- Koehler, M. J., & Mishra, P. Kereluik, K. Tae Seob Shin, and Charles Graham. (2009). What is technological pedagogical content knowledge? *Contemporary Issues in Technology and Teacher Education* 9(1), 60-70.
- Linda Darling-Hammond, John Bransford, Pamela LePage, & Karen Hammerness. (2007). *Preparing Teachers for a Changing World: What Teachers Should Learn and Be Able to Do*. USA: Jossey-Bass.
- Postholm, M. B. (2012). Teacher's professional development: a theoretical review. *Educational Research*, 407.
- Ugur Kale, Abhik Roy, & Jiangmei Yuan. (2020). To design or to integrate? Instructional design versus technology integration in developing learning interventions. *Education Technology Research Development*, 68:2473-2504.
- Vygotsky, L. (1978). *Mind in society. The development of higher psychological processes*. Massachusetts: Harvard University Press.
- Бадамцэцэг, Д. (2015). Багш нар ажлын байран дээрээ багаар хөгжих нэгэн боломжийг судалсан нь. *Магистрийн ажил*. Улаанбаатар.
- Байгалмаа, Ч. (2009). Багш, мэргэжлийн практик үйл ажиллагаандаа тулгуурлан хөгжих явцын судалгаа. *Диссертац*. Улаанбаатар.

- Батхуяг, С. (2020). *Боловсролын философи Орчин үеийн үзэл санаа*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Берт Криймерс, Леонидас Кириакайдс & Панаиотис Антонио. (2013). *Багшлахуйн чанарыг сайжруулахад Багшийн хөгжил*. Лондон: Спринжер.
- БМДИ. (2018). *itpd.mn*. Retrieved from <http://itpd.mn/press/>
- Булган, Б. (2014). Бүтээгч багшийн хөгжил төлөвшлийг дэмжих төсөлт ажлын онол аргазүйн судалгаа. *Диссертац*. Улаанбаатар.
- Бурмаа, Ц. (2013). Continuing teachers development. *Багш боловсролын шинэчлэл олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*. Улаанбаатар.
- Бэгз, Н. (2008). *Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Жадамбаа, Б. (2019). Улсын хөгжил хүнээсээ, хүний хөгжил багшаасаа, багшийн хөгжил бодлогоосоо. *Монголын багш нарын 7-р их хурлын шийдвэрүүд*. 54-59. Улаанбаатар.
- Пүрэвдорж, Ч. (2011). *Багшлахуйн менежмент*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Some Latest Researches on Teachers' Professional Development

Amartuvshin Deleg^{1*}, Odgerel Tsogt²

¹Mathematics and Science department, Teacher's School,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, MONGOLIA

²Dean, Seventh School, Orkhon Province, Erdenet, MONGOLIA

*Corresponding author: amartuvshind@msue.edu.mn 

Received: 11/24/2020/

Revised: 4/07/2021

Accepted: 5/12/2021

Abstract

The aim of this study is to get familiar with the latest researches on teachers' professional development and to find out the basis and methodologies of research on teachers' development as well as effective models of teachers' professional development. In accordance with the aim of the study, the method of analysis of sources and documents was used in the study. A total of 19 recent articles by Mongolian and foreign researchers on teachers' professional development were selected, four of which are reviews analyzing more than 30 articles each. To sum up the results of the selected articles, the main focus is on determining the methods of teacher's professional development and selecting the most effective models, the relationship between teachers' professional development and information and communication technology (ICT) and the way ICTs affect the tendencies in the teachers' professional development. In addition to attending integrated workshops for teachers' professional development, it is possible for teachers to develop in the workplace through collaborative and creative activities and to support teachers' professional development through the integration of the subject knowledge, teaching methods, and ICT skills.

Keywords

Model of teachers' professional development, ICT, TRACK